



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠐᠑ сарын ᠒᠐ өдөр

Дугаар А/᠒᠑8

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн “Баянбигэр” БГБХН
өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 21 нэр төрлийн нийт 18,706,513.00 (арван найман сая долоон зуун зургаан мянга таван зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Баянбигэр” БГБХН өрхийн эрүүл мэндийн төв (И.Мөнгөнцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 150,000.00 (нэг зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, 20 нэр төрлийн татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 18,556,513.00 (арван найман сая таван зуун тавин зургаан мянга таван зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн “Баянбигэр” БГБХН өрхийн эрүүл мэндийн төв (И.Мөнгөнцэцэг)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюунмаа* В.ОЮУМАА



1/᠒᠑᠒0111᠒᠑



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 03 дүгээр сарын 00 -ны өдрийн А.У.Х дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр : Сонгинохайрхан дүүргийн "Баянбигэр" БГБХН өрхийн эрүүл мэндийн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	УХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Цэрний хөргөгч	15	ш	1	145,000.00	145,000.00	145,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
2	Цэр зөөх цунх	15	ш	1	64,000.00	64,000.00	64,000.00	-	эвдэрсэн	актлах	500.0	татах	татах
3	Амбуу	15	ш	1	110,000.00	110,000.00	110,000.00	-	эвдэрсэн	актлах	500.0	татах	татах
4	Поток	14	ш	1	658,803.00	658,803.00	658,803.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
5	ЭХО	11	ш	1	3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
6	Ургийн доллар	10	ш	1	280,000.00	280,000.00	280,000.00	-	эвдэрсэн	актлах	500.0	татах	татах
7	Шээсний шинжилгээний	10	ш	1	1,700,000.00	1,700,000.00	1,700,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
8	Тест уншигч аппарат Gefin100	6	ш	1	3,500,000.00	3,500,000.00	3,500,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
9	Ширээний компьютер 2020	5	ш	1	2,485,424.00	2,485,424.00	2,485,424.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
10	Зөөврийн компьютер Dell i5-2017	8	ш	1	1,599,900.00	1,599,900.00	1,599,900.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
11	Компьютер Dell-i5-2017	8	ш	1	1,677,235.00	1,677,235.00	1,677,235.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
12	Өнгөт принтер 360-2017	8	ш	1	429,900.00	429,900.00	429,900.00	-	эвдэрсэн	актлах	1,000.0	татах	татах
Тоног төхөөрөмжийн дүн											10,500.0		
2.Тавилга эд хогшил													
13	Лед самбар	12	ш	1	620,000.00	620,000.00	620,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000.00	татах	татах
14	Жижиг сандал	11	ш	2	50,000.00	100,000.00	100,000.00	-	эвдэрсэн	актлах	500.00	татах	татах

